



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/408

Мандалговь

Газар эзэмшүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Одоо байгаа цэвэрлэх байгууламжийн зүүн хойд талд)-т байршилтай 900 м<sup>2</sup> (0,09га) газрыг иргэн Шатар овогтой Сарангэрэл (ЗЮ:64071167)-т үйлчилгээний зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ГХБХБГазар, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

433010302